



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 11377

Номгон

Г Т
Иргэн Г.Бадангаравт газар эзэмшүүлэх
тухай


Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 81 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сумын Номгон 1 дүгээр баг, Лувсанданзанжанцангийн өргөн чөлөө-5, 501ж тоот хаягт байрлах 12-р байрны өргөтгөлийн зориулалтаар иргэн Г.Бадангаравын (ВР94012120) эзэмшихийг хүссэн 82 м2 газрыг дуудлага худалдааны анхны үнийг 2 дахин өсгөн нөхөн төлбөр төлүүлж, худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалтаар эзэмшүүлсүгэй.

2.Эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн "Э" дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг газар эзэмшигч иргэнд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621010949